

СОЦИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУДЛАХ ЗҮЙЛИЙН АСУУДАЛД

В.Отгоннасан
Социологийн ухааны доктор

Социологийн шинжлэх ухаанд түүний судлах зүйлийн асуудал өнөөдөр нэн тулгамдсан асуудал болж байна. Энэ нь наад зах нь гурван шалтгаантай. **НЭГДҮГЭЭРТ**, Социологийн шинжлэх ухаан өөрөө харьцангуй шинэ, ялангуяа, монголд жинхэнэ утгаараа хөгжиж чадаагүй одоо л анх удаа зөв байр суурин дээр тавигдах бололцоо гарч байгаа нь юу юуны өмнө уг ухааны судлах зүйлийн асуудлыг нухацтай авч үзэх шаардлагыг төрүүлж байна. Хүн амын өргөн давхаргын ердийн ухамсарт төдийгүй нийгмийн ухааны онолын хүрээнд ч социологийг шинжлэх ухаан болохынх нь хувьд үзэх янз янзын төсөөлөл байсаар байна. Социологид хандах эдгээр үзэл төсөөлөлд үндсэн хоёр хандлага зонхилж байна. Үүнд:

1. **Социологийг нийгмийн тухай бүхий л мэдлэгтэй адилтгах хандлага.** Энэ нь захиран тушаах тогтолцооны үеийн нийгмийн сэтгэлгээний хэв загвараас улбаатай «инерцийн сэтгэлгээ» юм. Ийм үзэл нийгмийн тухай философийн хийсвэрлэлээр «хүмүүжсэн» философичдын дунд багагүй байдаг. Социологийг ойлгох иймэрхүү төсөөлөл нь эцсийн эцэст манай оронд социологи нийгмийн бие даасан тодорхой шинжлэх ухааны хувьд, философийн бүрэлдэхүүн хэсэг бишийн хувьд, бүрэлдэн бий болж хөгжихөд саад тотгор болсоор байна.

Чухам үүнтэй холбогдон философи болон социологийн харьцааны тухай асуудлыг судлах боловсруулах нь чухал болж байгаа юм. Энэ бол манай оронд социологийн ч, философийн ч аль алины хөгжлийн цаашдын хувь заяатай холбогдсон тулгамдсан асуудал мөн. Ялангуяа нийгмийн тухай цэвэр социологийн онол /социологийн ерөнхий онол/ ба нийгмийн философийн зааг ялгаа, уялдаа холбоог тодруулах нь философичид, социологичдын хойшлуулшгүй чухал зорилтын нэг болж байна. Түүнийг шийдвэрлэх гэсэн аливаа оролдлого хүссэн хүсээгүй социологийн судлах зүйл юу юм бэ гэдэг асуудалд тулж очно.

2. **Мөн нийгмийг болон хүнийг судлах арга, нийгмийн бусад шинжлэх ухаанд шаардлагатай баримт сэлтийг хуримтлуулж бий болгох хэрэгсэл** төдийгөөр социологийг ойлгох нь цөөнгүй байна. Энэ нь хүмүүсийн ердийн ухамсарт төдийгүй нийгмийн ухааны зарим төлөөлөгчдийн үзэл бодолд ажиглагддаг. Тухайлбал, политологийн судалгааны арга мэт ярьж бичих, политологи, улс төрийн социологи, социологийн зааг ялгааг тодорхой гаргахгүй тэдгээрийн судлах зүйл, судалгааны хандлагыг хутгаж саармагжуулах байдал илэрч байна.¹

Социологид ингэж хандаж, төсөөлөх нь эцэстээ түүнийг «социографи»-тай адилтгаж утга чанарыг нь ихээхэн бууруулж буй хэрэг юм. Ийм өрөөсгөл хандлага бол социологи болон нийгмийн бусад тодорхой ухааны холбоо, харьцааны асуудлыг нухацтай авч үзэх шаардлагатайг харуулах бөгөөд ингэх нь мөн л социологийн судлах зүйлийн асуудалд хүрч очих билээ.

Дээр дурдсан хоёр төрлийн өрөөсгөл хандлага нь ерөөсөө метасоциологийн, түүний дотор социологийн дотоод институтчиллийн асуудал ялангуяа түүний цөм нь болох социологийн судлах зүйлийн судалгаа ихээхэн тулгамдаж байгаагийн нотолгоо мөн.

Социологийн судлах зүйлийг онцгойлон авч үзэх **ХОЁРДАХЬ ШАЛТГААН НЬ** социологийн судалгааны практиктай шууд холбогдох юм. Ардчилал шинэчлэлийн үр дүнд манай оронд социологийн судалгааны аргаар олон нийтийн санал бодлыг судлах, нийгмийн судалгаа хийх үйл ажиллагаа өргөжиж байгаа нь сайшаалтай. Үүний хамт тэр болгоныг социологийн судалгаатай адилтган ойлгох, хандах нь ихэд түгээмэл болов. Социологийн эмпирик судалгаа гэдэг нь дээр дурдсан элдэв төрлийн судалгаанаас судалгааны урьдчилан боловсруулсан арга зүй /программ/ мэдээлэл авах, боловсруулах, тайлбарлах өвөрмөц аргаараа ялгаатайг эс тооцлоо гэхэд **нэгдүгээрт**,

1 А.Цанжид. Улс төр судлал. Цуврал лекц. I хэсэг. УБ. 1991; Улс төрийн шинжлэх ухааны үндэс. 1992 УБ.

нийгмийн социаль хууль, зүй тогтлыг илрүүлэхэд чиглэгддэгээрээ, хоёрдугаарт, нийгмийн үзэгдэл юмсыг судлах социологийн өвөрмөц хандлагаараа, гуравдугаарт, социологийн өөрийн «хэл»-ний /тусгай ойлголт, категорийн/ тусламжтайгаар нийгмийн үзэгдлийг «харж» судалдагаараа ялгагдах зарчмын өөр зүйл мөн. Эдгээр ялгааны аль аль нь социологийн судлах зүйлтэй шууд холбогдох тул социологийн судалгааны практиктай холбож судлах зүйлийн асуудлыг нарийвчлан боловсруулах шаардлага ч бас байгаа юм.

Социологийн судлах зүйлийг тухайлан авч үзэх ГУРАВДАХЬ ШАЛТГААН нь сургалт, танин мэдэхүйн үйл ажиллагаатай холбоотой, өөрөөр хэлбэл социологи нь өнөөдөр манай орны их дээд сургууль, коллежид бие даасан судлагдахуун болж байгаа /цаашид энэ үйл явц улам өргөжих нь зах зээлийн орнуудын практикаас тодорхой/ ялангуяа МУИС-д социологийн салбар нээн үндэсний мэргэжлийн социологичдыг бэлтгэж эхэлсэн нь уг шинжлэх ухааны судлах зүйлийн тухай нэгдмэл ойлголтыг бүрдүүлэх шаардлагыг бас төрүүлж байна.

Энэ бүхэн социологийн судлах зүйлийг нарийвчлан тодорхойлох ажил шинжлэх ухааны нэн тулгамдсан асуудал болж байгааг харуулж байна. Тухайлбал хуучин ЗХУ-ын философи, социологийн гол сэтгүүлд уг асуудлаар 60-70-аад оны үед явагдсан маргаан дахин сэргэж хүчтэй өрнөж байгаа нь санамсаргүй хэрэг бишээ.²

Ийм нөхцөлд социологичид, философичид болон Өрнө Дорнын эрдэмтдийн дунд ч өөр хоорондоо ялгаатай саналууд байсаар байна.

Социологийн эрдэм судлалын хүрээнд судлах зүйлийн тухай ойлголт зарим талаар нэг мөр болоогүй, бүүр эсрэг тэсрэг байр суурь ажиглагдах тохиолдол ч байна. Тухайлбал Оросын ШУА-ын «Социологийн судалгаа» /СоцИС/ сэтгүүлийн хуудсанд одоогийн явагдаж буй маргааныг ажиглаваас үндсэндээ хоёр урсгал байна гэж үзэж болохоор ажээ. Үүний эхнийхийг нь «философийн социологи» гэж нэрлэж болохуйц агаад энэ чиглэлийн төлөөлөгчид социологийн судлах зүйлийг тайлбарлахдаа «систем» гэдэг ойлголтыг тулгуур үндэс болгож түүхийн материализмыг ямар нэг байдлаар хадгалан социологийг философийн хүрээнд үлдээх эрмэлзэлтэй байх юм. Хоёрдахь арай зонхилох шинжтэй урсгалыг «цэвэр нийгмийн социологи» /социальная социология/ гэж нэрлэж болмоор бөгөөд энэ нь «нийгмийн нийтлэг» гэдэг ухагдахууныг тулгуур үндэс болгон авч социологийн судлах зүйлийг ялган гаргаж, түүнийг философийн «харьяаллаас» гарган тусгаарлах чиглэлтэй байна.

Ер нь өрнө дахины хийгээд хуучин социалист гэгдэгч орнуудын социологичдын гол гол бүтээл, ном зохиол, толь бичиг, сурах бичиг сэтгүүлийг шүүн үзэхэд социологийн судлах зүйлийн тухай 20 гаруй тодорхойлолттой тааралддаг. Энэ бүх тодорхойлолт үзэл бодлыг харьцуулан дүгнэвэл тэдгээрт дараах үндсэн гурван төрлийн хандлага зонхилж байна. Үүнд:

А/ Социологи бол нийгмийн тухай шинжлэх ухаан мөн.

Б/ Социологи бол нийгмийн нийтлэг, тэдгээрийн хоорондын харилцааг судална.

В/ Социологи нь хүн /бие хүн/, хүний нийгмийн үйл ажиллагааг судална гэсэн ерөнхий утгаар социологийн судлах зүйлийг тодорхойлсон байдаг.

Социологийн судлах зүйлийн тухай эдгээр үзэл бодол, тодорхойлолтын аль аль нь буруу биш боловч бүрэн хангалттай гэж хараахан үзэж боломгүй. Аль ч тохиолдолд тодорхойлсон байдлаар нь хязгаарлавал социологийн судлах зүйлийг бүрхэгдүүлэн одоогийнх шиг социологичдод өөрсдөд нь ч, бусад шинжлэх ухааны төлөөлөгчдөд ч тодорхойгүй хэвээр үлдэхэд хүрнэ. Түүгээр ч үл барам,

2 Комаров М.С. «Размышление о предмете и перспективах социологии» СоцИС 1990, 011,

Ядов В.А. «Размышление о предмете социологии». СоцИС 1990, 02

Руткевич М.Н. «Предмет и структура социологической науки» /Социал.исслед. 1981. 01/

Федосев П.Н. «К вопросу о предмете марксистской ленинской социологии» Социал.исслед. 1982, 03

Харчев А.Н. «Предмет и структура социологической науки» Социал. Исслед. 1981, 02

Кабыша А.В. «Научный статус исторического материализма и предмет социологии» СоцИС. 1990 04

Штомка П. «Много социологии для одного мира» СоцИС, 1991 02

Бороньев А.О., Ельмеев В.Я., Орлов В.Н. «О предмет социологии как общей науке об обществе» СоцИС 1991 05

Козлова О.Н., Панферова В.В., Спасибенко С.Г. «Социология в вузе: к вопросу о предмете и месте в системе общественных дисциплин» Социально-полит. науки, 1991. 02

дээрх гурван тодорхойлолтонд орсон нийгэм, нийгмийн нийтлэг, бие хүн гэсэн нэгдмэл ойлголтуудыг харилцан холбоонд нь авч үзээгүйгээс социологийг үзэх өрөөсгөл баримтлал гажуудалд хүрч болно. Тийм туйлшрал социологийн түүхэнд багагүй байсан бөгөөд одоо ч ажиглагдсаар байна. Иймээс эдгээр хандлага бүрийг, тэдгээрийн уялдаа холбоог нягтлан үзэж дүгнэлт хийх нь зарчмын ач холбогдолтой.

Энэ үүднээс дээр дурьдсан үзэл баримтлал бүрд дүн шинжилгээ хийсний дүнг товч авч үзье.

Нэг. Социологи бол нийгмийг бүхэлд нь судалдаг шинжлэх ухаан гэдэг эхний хандлагыг³ философис «төрсөн» социологичид ихэвчлэн баримталдаг. Мөн философичид социологийн тухай ярихдаа ийм хандлагыг сонгох нь олонтой. Манайд өнөөдөр чухамдаа энэ баримтлал багагүй байгаа нь социологич, нийгмийн тухай судалж бичигчдийн ихэнх нь философичид болохтой холбоотой болов уу. Харин энэ чиглэлийг хэт туйлчлан нийгмийн, түүний социаль бүтцийн үндсэн элементүүд болох нийгмийн нийтлэг, бие хүнтэй нягт холбоо, харилцан үйлчлэлд нь авч үзээгүйгээс «философижсон социологи» гэж нэрлэхимээр нэг төрлийн туйлшралд хүрдэг ажгуу. Тухайлбал СоцИС сэтгүүлд явагдаж буй маргаанаас ажиглагдах дээр дурьдсан эхний урсгал үүнд хамаарагдана. Нийгмийг бүрдүүлэгч эд, эс /нийтлэг, бие хүн/-ээс гадуур «хоосон» нийгмийн тухай догматик сургаал үүсэх бололцоо их хэмжээгээр агуулдагт энэ үзэл хандлагын өрөөсгөл шинж, болгоомжилвол зохих зүйл оршино.

Социологийн судлах зүйлд ингэж хандсанаар цаашид социологи нь бие даасан шинжлэх ухаан биш, харин философийн хүрээнд ямар нэгэн утгаар хамаарахад хүрдэг. Социалист гэгдэж байсан манай орнуудад хуваарьгүй ноёрхож ирсэн «түүхийн материализм бол нэг талаас нийгмийн тухай философийн онол бөгөөд нөгөө талаас социологийн ерөнхий онол мөн»⁴ гэсэн номнол нь чухамхүү энэ л логикийн үр дагавар мөн. Шинжлэх ухаан судлалын үүднээс үзвэл дотоод логик зөрчилтэй, энэ үзэл хандлага манай орнуудад албан ёсны зүйл болж улмаар социологи бие даасан шинжлэх ухааны хувьд зүй ёсныхоо дүр төрхийг олж хөгжих бололцоог хаагдуулагч гол саад болж ирэв.

Социологи нь аль ч шинжлэх ухааны адилаар онол, аргын нэгдэл бөгөөд түүний ерөнхий онолыг түүхийн материализм нэртэйгээр (чухамдаа нийгмийн тухай философийн асуудлуудтай хольж хутган) философийн хийсвэрлэлийн хүрээнд механикаар «өөд татан» нэгтгэж, харин социологийн тусгай, салбар онолыг эмпирик судалгааны хамт «хэрэглээний социологи» нэртэйгээр тусгаарлан холдуулж өнчилж, хязгаар тавьж байсанд энэ саад тогторын утга учир оршино. Социологийн судлах зүйлийг бүрхэгдүүлэх, гуйвуулах энэ хандлага нь манайд сайн, муу аль ч талаараа нөлөөлж ирсэн орон болох хуучин ЗХУ-д 30-аад оны үеэс албан ёсны шинжийг олж, 60-аад оны үед ямар нэгэн утгаар эргэлзээнд орсон (яг энэ үеэр судлах зүйлийн асуудлаар социологийн утга зохиолд өргөн маргаан явагдсан) хэдий ч, 70, 80-аад оны үед ихээхэн хүчтэй дэлгэрсэн нь манайд нөлөөлжээ.

Социологи дэлхий даяар шинжлэх ухааны статусаа олох боломжит алхмууд жам ёсоор хийгдэж байсан ХХ зууны эхээр одоогийн социалист гэгдэж байсан орнуудад социологийг нийгмийн тухай шинжлэх ухаан гэж үзэх энэ хандлага байсан боловч дээр дурьдсантай харьцуулахад үлэмжийн зөв дүр төрхтэй байжээ.

Ганцхан жишээ дурьдахад Оросын анхны томоохон социологичдын нэг Н.И.Кареев /1850- 1931/ бичихдээ: Социологи бол амьдралын тухай сургаал гэдэгтэй төсөөтэй нийгмийн тухай сургаал байх ёстой бөгөөд түүнийг үгийн өргөн, нарийн хоёр утгаар ойлгож болно. Өргөн утгаар, нийгмийн дотор юу оршин тогтнож байгаа тэр бүх юмс үзэгдлийн захирагдаж байгаа хууль зүй тогтлыг судална, өөрөөр хэлбэл, нийгэм-биологийн, нийгэм-сэтгэл зүйн, цэвэр нийгмийн /социаль/ хуулийг социологи судална. Харин цэвэр нийгмийн хууль нь үгийн явцуу утгаар социологийн судлах зүйл болно⁵ гэж тодорхойлсон байдаг. Тэрээр хувь хүний нийгмийн өөрчлөлтөнд гүйцэтгэх үүргийг ихээхэн анхаарч нийгэм бол биологийн, физикийн болон гадаад гэх мэт олон тооны хүчин зүйлсийн

3 Рабочая книга социолога. 1-е издание. М., Наука, 1976, 2-ие издание. М., Наука 1983-номноос ийм хандлагыг ажиглаж болно.

4 Рабочая книга социолога. 1-е издание. М., Наука, 1976. С12. 2-е издание, М., Наука 1983, С.27, Марксистско-ленинская социология /Отв.ред. I.В.Осипов, В.Н.Иванова-М. Наука, 1988, С.П

5 Кареев Н.И. Сбор.соч: В 3 т. СПб., 1911-13 Т.2.с.61

харилцан үйлчлэлийн үр дүн, нарийн нэгдмэл зүйл гэж үзэж байв. Ийм үзэл бодол өгүүлэн буй чиглэлд хамаарах боловч ямар нэгэн хийсвэр нийгмийн тухай биш, социаль шинжтэй эд, эсээс бүрдэх тодорхой нийгмийн тухай үзэл хандлага байснаараа илүү бодитой юм.

Өрнөдийн социологичдын дунд ч социологи нь нийгмийг бүхэлд нь судалдаг шинжлэх ухаан гэдэг үзэл хандлага цөөнгүй бий.

Тухайлбал английн социологичид **«социологи бол хүний нийгмийг судлах онцгой арга зам буюу нарийвчилбал хүмүүсийн нийгэмлэгүүдийг /нийтлэгүүдийг-В.О/ судлах онцгой арга зам»**⁶ гэсэн тодорхойлолт өгөөд цааш нь нийгэм, нийгмийн нийтлэг, бие хүн гэдэг ойлголтуудыг харилцан холбоонд нь авч үзэж, бүхэл бүтэн нийгмээс нь эхлэн нийгмийн нийтлэг, улмаар бие хүнийг судлах хүртэл социологийн зам мөрийг гарган нарийвчлан тайлбарласан байдаг. Чухамдаа ийм маягаар асуудлыг авч үзсэн нөхцөлд л нийгмийг судлах социологийн хандлагыг жинхэнэ дүр төрхөөр нь тодруулж чадах билээ.

Социологийн судлах зүйлийг нийгэм гэж тодорхойлсон нөхцөлд бидний үзэж байгаагаар доор дурдсан үндэслэлд тулгуурлавал л сая илүү бодитой болно. Үүнд:

Аливаа нийгэм бол нийгмийн нийтлэгээс гадуур оршихгүй, зөвхөн нийгмийн тодорхой нийтлэгүүд, тэдгээрийн харилцааны цогц хэлбэрээр л оршино. Нийгмийн нийтлэгүүдийн хоорондын харилцаа нь энэ нийтлэгүүдийн төлөөлөгч болон тусгай тусгайдаа орших бие хүний харилцаагаар л илэрнэ. Өөрөөр бас байхгүй. Бие хүнийг агуулаагүй орших нийгмийн нийтлэг гэж байхгүй.

Эдгээр үндэслэлийг иш үндэс болгосон цагт л социологи нь нийгмийн тухай шинжлэх ухаан гэж тодорхойлж болох зөв тавил бүрэлдэнэ.

Хоёр. Социологийн судлах зүйлийг тодорхойлохтой холбоотой хоёрдахь хандлагын гол агуулга нь социологи бол нийгмийн нийтлэг, тэдгээрийн хоорондын харилцаанд орших жам, зүй тогтлыг судалдаг шинжлэх ухаан гэж тодорхойлоход оршино.

Өрнөдийн социологи нь дотроо олон тооны урсгалтай боловч социологийн судлах зүйлийн тухайд дийлэнх хэсэг нь энэ чиглэлд нэгдэн нийлэх хандлагатай гэж үзэж болно. Тухайлбал Америкийн томоохон социологичдын нэг А.Гидденс /Кембриж/ «Социологи бол хүний нийгмийн амьдралын тухай, бүлэг хэсгийн тухай, нийгмийн тухай шинжлэх ухаан»⁷ гэж тодорхойлсон бол Тейлор /Нью-Йорк/ зэрэг социологичид «социологи бол нийгмийн социаль бүлгүүдийн тухай, хүний үйл ажиллагаанд эдгээрийн үзүүлэх нөлөөний тухай сургаал»⁸ гэжээ. Мөн социалист гэгдэж байсан орнуудын гол гол социологичид ч эхний үзэл баримтлалаас энэ баримтлалд шилжих хандлага ажиглагдаж байна. Тухайлбал хуучин Зөвлөлтийн В.А.Ядов⁹, Г.В.Осипов¹⁰ нарын зэрэг нэр бүхий социологичдын өмнөх үеийн бүтээл дэх үзэл бодлыг нэн сүүлийн үеийн үзэл баримтлалуудтай харьцуулбал энэ нь тодорно.

Мөн «СоцИС» сэтгүүлийн хуудсанд явагдаж байгаа маргаанд ажиглагдах хоёрдахь урсгал нь ч энэ чиглэлд хамаарна.

Энэ чиглэлийн аль ч тодорхойлолтыг авч үзсэн нийгмийг судлах эхлэлийн зангилаа цэг нь, түүний мөн чанарын гүнд дамжин орох цонх нь «нийгмийн нийтлэг» гэсэн ойлголт байх бөгөөд энэхүү нийгмийн нийтлэгүүдтэй, тэдгээрийн хоорондын харьцаатай холбоотой цэвэр нийгмийн /социальное-социале/ зүйлийг ерөөс нийгмийн /общественное-gesellschaft/ зүйлээс ялган социологийн судлах зүйлд хамааруулсан байдаг.

Социологийн судлах зүйлийг онцгойлон ялган товойлгох гэсэн оролдлого нь огт цоо шинэ зүйлс бас биш юм. Харин манайхны хувьд энэ цэвэр нийгмийн юм, ерөөс нийгмийн юм хоёрыг нэгэн адил «нийгэм» гэдэг нэр томъёогоор орлуулж /орчуулж/ ирсэн нь одоо ч үргэлжилж байгаа нь социологийн судалдаг чухам тэр зүйлийг бүрхэгдүүлэхэд хүргэдэг. Энэ нь бас социологи жинхэнэ

6 Hurd G1 and others. Human Societies an Introduction to sociology. L., 1986. Op.cit. P1

7 Giddens A. Sociology: Cambridge. 1989. Op.cit.p

8 Maylor M.C. Phyhe L.H., Posenthal St.J., Dorgbg K. Int to sociology N.Y. 1987. Op.cit., p4

9 В.А.Ядов «Социологическое исследование: методология, про методы» М., Наука, 1973. 1987. СоцИС 1990 Ё2

10 Г.В.Осипов «Теория и практика социологических исследования»

утгаараа хүнд ойлгогдож, тэр хэрээрээ зөв төрхийг олж хөгжихөд сөрөг нөлөө үзүүлж байгааг дурьдалтай.

Социологийн судлах зүйлийг нийгмийн нийтлэгтэй холбон тодорхойлох ийм оролдлого нь нэг талаас философи, нийгмийн бусад шинжлэх ухаан, нөгөө талаас социологийн хоорондын харилцааг тов тодорхой болгож, социологи нь нийгмийн бие даасан шинжлэх ухаан болохыг үндэслэхэд чухал ач холбогдолтой юм. Нөгөөтэйгүүр нийгэм ба бие хүнийг холбогч гол зангилаа болох нийгмийн нийтлэгийг тухайлан барьж авч судалснаар, тэдгээрийн харилцаа, холбооны нарийн механизмыг тодруулж, нийгмийн ч, нийтлэгийн ч, бие хүний ч мөн чанарыг бүрэн төгөлдөр гаргах илүү бололцоо бүрдэнэ.

Гэвч социологийн судлах зүйлийг нийгмийн нийтлэгийн хүрээгээр хязгаарлан явцуурвал социологи нь зөвхөн нийгмийн нийтлэгийн тухай юмуу сайндаа нийгмийн зөвхөн социаль хүрээг л судалдаг юм шиг өрөөсгөл ойлголт хандлагад хүргэж болох юм. Социологийн судлах зүйлийг ийнхүү явцууруулсан хандлагыг ном зохиолд «социаль социологи» гэж оновчтой нэрлэсэн нь бий. Үнэн хэрэгтээ социологи нь зөвхөн нийгмийн нийтлэгийн сайндаа тэдгээрийн хоорондын харилцаа болох нийгмийн социаль харилцаа социаль хүрээг л судалдаг «хэт явцуухан» зүйл хараахан биш ээ. Харин бие хүнийг ч, нийгмийг ч, нийгмийн доторхи аль ч үзэгдэл, юмс, үйл явцыг нийгмийн нийтлэгүүдийн харилцаатай холбон судалдаг түүний гол онцлог оршино. Ингэснээрээ социологи нь нийгмийн юмс, үзэгдлийг нийгмийн /социаль/ хүчин зүйлийнх нь дотор харилцан үйлчлэл нөлөөлөлд нь түүний оршин тогтнох, хөгжин өөрчлөгдөх жам зүйг судална. Энэ тохиолдолд нийгэм- биологийн, нийгэм-сэтгэл зүйн, нийгэм-эдийн засгийн, нийгэм-улс төрийн, нийгэм-оюун санааны гэх мэт аль ч үзэгдэл нийгмийн нийтлэг /хүн/, тэдний хоорондын харилцаатай холбогдох үүднээсээ социологийн судлах зүйлийн хүрээнд холбогдох юм.

Нийгмийн нийтлэг гэдэг ойлголтыг гол тулгуур болгон социологийн судлах зүйлийг тодорхойлохдоо нийгэм болон бие хүнтэй түүний харилцан нягт холбоогоор нь авч үзэхгүй бол боломжгүй. Чухам ингээгүйгээс л дээр дурдсан «социаль социологи» үүсэхэд хүрнэ. Социологийн судлах зүйлийг нийгмийн нийтлэгтэй шууд холбон тодорхойлохдоо бидний үзэж байгаагаар дараах үндэслэлүүдэд тулгуурлах нь энэхүү үзэл баримтлалын утга учрыг зөв гаргах үндэс болно. Үүнд:

Нийгмийн нийтлэг л аливаа нийгмийг бүрдүүлдэг, нийгэм бол социологийн үүднээс үзвэл нийгмийн нийтлэгүүдийн харилцааны цогц нийлбэрээс өөр зүйл биш. Нийтлэгийг агуулдаггүй «хоосон» нийгэм байхгүй. Нийгмийн нийтлэг нь нийгмийг бүрдүүлж оршин тогтнохдоо өөрийнхөө ээлжснд бие хүнээс л бүрдэнэ. Нийгмийн нийтлэг, тэдгээрийн харилцаа нь гагцхүү бие хүн, тэдгээрийн харилцаагаар илэрнэ. Өөрөөр бас байхгүй. Бие хүнийг агуулдаггүй түүгээр дамжин илэрч харилцдаггүй «хоосон» нийтлэг бас байхгүй.

Эдгээрийг тулгуур зарчмаа болгож нийгмийн нийтлэгээр дамжуулан нийгмийг ч, бие хүнийг ч судлахад социологийн энэ үзэл хандлагын гол утга учир орших бөгөөд энэ нөхцөлд л нийгмийн нийтлэгийн сонгон авдаг уг үзэл баримтлал өөрийн давуу талтай, хамгийн зөв оновчтой чиглэл болж байна.

Харин судлах зүйлийг тодруулахад тулгуур үндэс нь болж байгаа «нийгмийн нийтлэг» гэдэг ойлголтыг зөв төсөөлж тодорхойлох нь зарчмын ач холбогдолтой. Социологийг ойлгох гол зангилаа энэ чухал ойлголтыг тодруулах нь социологийн дотоод институтчиллын ч чухал асуудал мөн.

Социалист гэгдэж байсан орнуудын философи, социологийн ном, сурах бичгүүдэд авч тайлбарлаж ирсэн үндэстэн, ястан, овог, аймаг, сайндаа ард түмэн зэрэг түүхэн нийтлэгүүдээс «нийгмийн нийтлэг» гэдэг нь хавьгүй өргөн хүрээтэй ухагдахуун юм. Гэхдээ социологичид, эрдэмтдийн дунд энэ ойлголтын талаар өөр хоорондоо ялгаатай үзэл баримтлал байдгийн дээр нийтээр хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн, нэг мөр болгосон тодорхойлолт одоо хэр тохиолдохгүй байна. Гэхдээ сайн нягтлан үзвэл нийгмийн нийтлэг гэдэг энэ ойлголтын талаар социологичдын дунд тодорхой төсөөллүүд бий. Нийгмийн нийтлэгийн тухай шинжлэх ухааны тодорхойлолтыг томъёолох зорилгоор янз бүрийн төсөөллүүдийн ялгаатай болон ерөнхий талыг харьцуулан үзсэний үндсэн дээр дараах тодорхойлолтыг өгч болно гэж үзэж байна. Үүнд:

Нийгмийн учир холбогдол бүхий ерөнхий шинж чанартай, өөр хоорондоо социаль холбоогоор холбогдсон, эдгээрийнхээ эрхэнд нийгмийн дотор тогтвортой, бие даасан бүхэл нэгэн зүйл болон оршдог томоохон бүлэг хүмүүсийг нийгмийн нийтлэг гэнэ.

Энэ тодорхойлолт нийгмийн нийтлэгийг хүмүүсийн элдэв төрлийн бүлэг, бөөгнөрлөөс /жишээ нь марк сонирхогчид, үзвэр үзэгчид, шинийг санаачлагчид гэх мэт/ ялгах гол ялгаа болох тэдний социаль холбоо, ерөнхий шинж, тэдгээрийнх нь зайлшгүй тогтвортой чанар, бие даасан нэг цул бүтэн байдал зэргийг тодруулан өгч байгаагаараа ач холбогдолтой. Эдгээрийн дотроос нийгмийн учир холбогдол бүхий ерөнхий шинж, социаль холбоо гэсэн эхний хоёр онцлог чанар нь нийгмийн нийтлэгийг тодорхойлоход гол үүрэгтэй гэж үзэж байна. Ялангуяа энд «нийгмийн учир холбогдол бүхий» гэсэн тодотгол орж байгаа нь санамсаргүй хэрэг биш. Хүнийг чухамхүү хүн, өөрөөр хэлбэл, нийгмийн хосгүй амьтан, тодруулбал, нийгмийн социаль харилцааны цогц бүрдэл болгож байгаа тийм язгуур амин шинжээрээ ерөнхий, эсвэл тэр учир шалтгаанаараа өөр хоорондоо холбогдон хэлхэгдсэн байхыг л «нийгмийн учир холбогдол бүхий» шинж, холбоо хэмээн ярьж буй хэрэг юм. Хүн уг шинж чанараа, тэр холбоо хэлхээгээ алдвал хүн биш болж, нийгмийн зүйрлэшгүй мөн чанар нь өөрчлөгдөх тийм л шинж чанарууд хүнд өдий төдий байж болох бөгөөд чухам түүнтэй нь холбогдон үүсдэг томоохон бүлгүүдийг л нийгмийн нийтлэг хэмээн ойлговол зохих юм. Хүн нийгмийн дотор мэндлэн аж төрөхдөө аль нэгэн ястан үндэстний харьяалалд зайлшгүй багтдаг /ямар нэгэн угсаатныг төлөөлөхгүй хүн ерөөс оршихгүй/, мөн аль нэгэн насны үеийг төлөөлөн оршдог, хот хөдөөгийн аль нэгэн орон зайг эзлэн амьдардаг гэх мэт. Энэ бүгдийг тус бүрт нь тодорхойлж байгаа язгуурын зайлшгүй шинжүүд нь хүний социаль мөн чанарыг цогцлуулж, өөр хооронд нь холбож байдаг. Нийгмийн зайлшгүй үр дагавар болох үйлдвэрлэлтэй /оюуны ба материаллаг/ хүн ямар нэг шижмээр заавал холбогдох /ингэж байж бусадтай харилцаанд орж, хүний мөн чанар болон нийгмийн социаль харилцааны цогц бүрдэл хэсэг болно/ бөгөөд үүнтэйгээ уялдан нийгэм-ангийн, ажил мэргэжлийн томоохон бүлгүүдэд хуваагддаг. Ингэж хүн нийгмийн учир холбогдол бүхий шинж чанар, хэлхээ холбооноос хамаарч нийгмийн дотор томоохон бүлгийг үүсгэх бөгөөд тэдгээрийг нь нийгмийн нийтлэг хэмээн нэрлэж буй хэрэг юм.

Ямар ч нийгэмд байдаг нийгмийн томоохон нийтлэгүүд гэвэл анги давхарга зэрэг **нийгэм-ангийн нийтлэгүүд**, үндэстэн, ястан зэрэг **угсаатны нийтлэгүүд**, нас, хүйс, гэрлэлт зэрэг хүн ам зүйн шинжээрээ өөр хоорондоо ялгагдах **хүн ам зүйн нийтлэгүүд**, нийгмийн үйл ажиллагаа эрхэлдэг ажил мэргэжлээрээ ялгагдах **нийгэм-мэргэжлийн нийтлэг**, оршин амьдрах орчин, байршил, орон зайн шинжтэй холбогдох /хотынхон, хөдөөгийнхөн г.м/ **нутагшилтын нийтлэг**- үүдийг тус тус дурдаж болно.

Нийгмийн нийтлэгийг дээрх байдлаар тодорхойлсон нөхцөлд социологийн зөвхөн судлах зүйл төдийгүй, түүний хамрах хүрээ мэдлэгийн багтаамжийг арай тодорхой авч үзэх бололцоо бүрдэнэ. Үүнд: Нийгмийн нийтлэг бүхэн нь дотооддоо болон өөр хоорондоо зайлшгүй харилцан нөлөөлж, харилцан үйлчилж байж, нийгмийн өөрчлөлт хувирлыг нөхцөлдүүлнэ. Нийтлэг бүр энэ харилцан нөлөөлөл үйлчлэлээрээ тодорхойлогдох нийгмийн учир холбогдол бүхий тодорхой харилцааны /жишээлбэл, ангийн, үндэстний, гэр бүлийн, залуу ахмад үеийн, нийгэм-мэргэжлийн, хот хөдөөгийн гэх мэт/ субъект болно. Энэ харилцаанууд нь нийлбэр цогцоороо тухайн нийгмийн **социаль харилцааг** бүрдүүлнэ. Нийгмийн социаль харилцаа нь өөрийнхөө ээлжинд хүний санаа зоригоос үл хамаарах, объектив, дахин давтагдах зайлшгүй шинжтэй жам ёсоор явагдана.

Энэ ёс жам, зүй тогтлыг нийгмийн **социаль хууль** гэх бөгөөд тэр нь чухамдаа социологийн шинжлэх ухааны судлах зүйл нь болой.

Социологи нийгмийн социаль харилцааг судлахдаа энэ харилцааг төдийгүй, түүний субъектив илэрхийлэл, тусгал болох бие хүний нийгмийн учир холбогдол бүхий /социаль/ хэрэгцээ, сонирхол, үнэт зүйлс, санал бодол, төсөөлөл, үзэл баримтлал, энэ социаль харилцаа явагдах нийгмийн орчин төдийгүй энэ харилцааны албан ёсны хийгээд бодит илрэл болох давхаргын чанартай элементүүдийг /гэр бүл, үйлдвэрлэлийн хамтлаг, социаль бусад институтууд г.м/ харилцан шүтэлцээнд нь судална. Нийгмийн социаль харилцаа, түүний дээр дурдсан объектив, субъектив илрэл нь хамтдаа **нийгмийн**

социаль хүрээг бүрэлдүүлнэ. Зарим социологичид социологи нь нийгмийн социаль хүрээг судалдаг гэж бичсэн байдаг нь үүнтэй холбоотой. Тухайн тодорхой нийгэм олон тооны нийтлэгээс тогтох бөгөөд тэдгээрийн харилцаа, хувь хэмжээ эзлэх байр суурь, байршлыг нийгмийн социаль бүтэц гэнэ. Социаль бүтэц нь нийгмийн социаль хүрээний гол ноён нуруу /араг яс/-ыг босгож социаль харилцааны үндсэн чиг хандлагыг тодорхойлох учир социологийн гол судлагдахууны нэг болно.

Ингэж социологи гэж чухам юу болох, ямар хүрээг хамрах зэрэг социологийн үндсэн асуудлуудыг нарийвчлан тодотгох өргөн бололцоо олгож байгаагийн хувьд, нийгмийн нийтлэгийг гол болгодог өгүүлэн буй энэ хоёрдахь үзэл баримтлал илүү үнэмшилтэй юм.

Гурав. Социологийн судлах зүйлийг тодорхойлохтой холбоотой гуравдагч урсгал нь социологи нь хүн /бие хүн/, түүний зан үйлийг судлах шинжлэх ухаан гэж үздэгт оршино. Энэ талыг баримтлагчид социологийн гол объект нь хүн, түүний үйл ажиллагаа гэж үзэхдээ хүний социаль мөн чанар болох бие хүнийг нийгмийн социаль харилцааны цогц болох талаас нь ханддаг. Тусгай тусгайдаа байгаа хүнийг биш, харин бусадтай харилцан үйлчлэл холбоо хамааралд оршин буй хүнийг судалдагараа социологичид бусад нийгмийн ухааны төлөөлөгчдөөс ялгарах ёстой. Америкийн социологич Н.Смелзер «социологи гэдгийг энгийнээр хэлбэл хүн судлах арга мөн»¹¹ гэж тодорхойлжээ. Тэр энэ товч томъёоллоор хязгаарласангүй цааш бичихдээ: Социологичид хүмүүс өөрөөр биш чухам яг ийм байдлаар нийгмийн дотор амьдардаг, яагаад тэд янз бүрийн бүлэг үүсгэж, яагаад тэмцэлдэж, дурлаж, гэрлэж, санал бодлоо илэрхийлдэг, ер нь хүмүүс бие биетэйгээ харилцан үйлчлэхэд үүсдэг тэр бүх зүйлийг мэдэхийг хүсдэг гээд» . . . товчоор хэлбэл социологийг нийгэм болон социаль харилцааг шинжлэх ухааны үүднээс судлах гэж тодорхойлж болно»¹² гэжээ.

Социологийн судлах зүйлийг ийм маягаар тодорхойлох нь өрнөдийн социологийн сурах бичгүүдэд түлхүү байдаг нь амьдралд илүү ойр дөт, ойлгомжтой болгохыг эрхэмлэдэгтэй холбоотой.

Энэ чиглэлийн ихэнх төлөөлөгчид эхлээд хүнийг /бие хүнийг/ аваад түүний бусадтай холбогдох харилцан үйлчлэлээр нь дамжуулж нийгмийн нийтлэг болон социаль харилцаа, улмаар бүхэл нийгмийг судлахад хүрч очдог. Энэ нь чухамдаа бие хүн, нийтлэг, нийгмийг тэдгээрийн харилцан үйлчлэлд нь авч үзэж буй хэрэг бөгөөд ганцхан онцлог нь бие хүнээс гараагаа эхэлж, нийтлэг болон нийгмийг судалж байгаад оршино. Ийм замаар судлах зүйлийг тодорхойлоход эцсийн дүндээ дээр ярьсан нөгөө хоёр чиглэлээс зарчмын хувьд гажих дүгнэлтэнд хүргэхгүй юм.

Харин социологи хүнийг судалдаг гээд түүний бусад хүмүүстэй харилцан үйлчилж байж л социаль мөн чанарыг олдог, ингэж байж тэр мөн чанар нь илэрдэг гэдгийг эс ойшоон саланги тусдаа юмуу ерөөс хүнийг л судалдаг гэсэн чиглэлийг баримталбал бас нэгэн явцууралт, хазайлт бий болно. Социологийн түүхэнд сэтгэл зүй, физиологийн, биологийн зэрэг олон урсгалууд гарч байсан нь үүнтэй холбоотой.

Бидний үзэж байгаагаар, социологи хүн судалдаг гэж тодорхойлохдоо «хүний мөн чанар нь бие хүн бөгөөд тэр нь нийгмийн социаль харилцааны цогц мөн. Хүн нийгмийн дотор бусад хүнтэй харилцаж байж л мөн чанараа олно. Бие хүн нийгмийн олон тооны нийтлэгийн төлөөлөгч байдалтай л оршино. Нийтлэгээс гадуур ямар ч нийтлэгт үл багтах бие хүн гээч үгүй. Хүн нийгмийн дотор төлөөлөн буй нийтлэгийнхээ бүрдүүлэгч нь болж, хүссэн хүсээгүй түүний ашиг сонирхлын ул мөрийг үлдээх замаар л мөн чанараа хадгалан оршино. Хүн ингэхлээр нийгмийн дотор нийгмийн нийтлэгээр дамжин түүнтэй харилцан үйлчилж, нийгмийн эс, эд болно» гэдгийг иш үндэс болгон бие хүнээс нийгмийн нийтлэг, нийгмийн нийтлэгээс бүхэл нийгмийг дамжин судлах социологийн зам мөрийг гаргавал социологийн судлах зүйлийг төгс гаргаж чадах юм.

Социологийн судлах зүйлийг тодорхойлох талаар тохиолддог үндсэн гурван үзэл баримтлалыг шинжилсний дүнд дараах ерөнхий дүгнэлтийг хийж болно:

Дурдсан гурван үзэл баримтлал нь социологи гэдэг бүхэл шинжлэх ухааны судлах зүйлийг зарчмын ялгаатай гурван өөрөөр авч тодорхойлсон хэрэг огт биш бөгөөд харин зөвхөн авч үзэж

11 Smelser N. Sociology. New Jersey. 1988. Op. cit.p16

12 Smelser N. Sociology. New Jersey. 1988. Op. cit.p16

буй арга, хандлагын ялгаа мөн. Чухамдаа нэгэн зүйлийн тухай төсөөллийг гаргахдаа замнаж болох гурван өөр замаар явсны үр дүн. Эхлэлийн цэгийг гурван өөр түвшнээс авсны үр дүн юм. Учир нь нийгэм, нийгмийн нийтлэг, бие хүн гэдэг бол нэгэн зүйлийг төсөөлж болох гурван түвшин, нэгэн зүйлийн оршин байгаагийн гурван илрэл мөн. Чухамдаа аль нь ч нөгөөгүйгээр байхгүй бөгөөд оршин байгаа нь нөгөө хоёроороо дамжин илэрнэ. Тодорхой бие хүн нь өөрөө нийгмийн харилцааны цогц болох хувьдаа бүхэл нийгэмээ ч, нийтлэгээ ч өөртөө тээж явдгийн адил нийгэм ч, нийтлэг ч бие хүнээ агуулж, нийтлэг нь ч нийгэм болон бие хүнээ тодорхойлно. Нийгэм ямар байна хүн тийм байна. Хүн ямар байна, нийгэм бас тийм байна. Нийтлэггүйгээр энэ нь хэрэгжихгүй г.м.

Энэ бүгдээс дүгнэвэл:

СОЦИОЛОГИЙН СУДЛАХ ЗҮЙЛ НЬ «НИЙГЭМ-НИЙТЛЭГ-БИЕ ХҮН» ГЭСЭН ГУРАМСАН БҮТЭЦТЭЙ НЭГЭН ЦУЛ ЗҮЙЛИЙН ОРШИН ТОГТНОХ, ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨХ ЗҮЙ ТОГТОЛ МӨН.

Социологи нь «НИЙГЭМ-НИЙТЛЭГ-БИЕ ХҮН» гэсэн нэгэн хосгүй цул зүйлийг судлахдаа аль ч түвшнээс нь эхэлж зам мөрөө гаргаж болох бөгөөд хаанаас нь ч эхэллээ гэсэн харилцан үйлчлэл, нягт холбоо хамааралд нь авч үзэхэд социологийн онцлог оршино.

Харин социологийн ерөнхий хөгжлийн онцлог, тухайн улс орон дахь хүн амын социологийн соёлын түвшин, социологийн үйл ажиллагааны зорилго, гүйцэтгэж буй үүрэг зэрэг олон зүйлээс хамааран аль нэгэн тодорхой хандлагыг голчлох нь ашигтай, үр нөлөөтэй байж болно. Тухайлбал бүхэл нийгмийн тухай социологийн үзэл онол боловсруулах зорилготой бол нийгмийн, социологийн дотоод институтчиллийг нарийвчлан боловсруулах бусад шинжлэх ухаантай холбогдох харилцааг тодорхой болгоход нийгмийн нийтлэгийн, эхлэн суралцагчдад социологийг ойлгуулах, амьдралд ойр дөт, сонирхолтой болгох үүднээс бие хүний хандлагыг сонгон социологийн судлах зүйлийг тайлбарлаж болох жишээтэй.

Харин дээр яригдсан бүхнийг нэгтгэн дүгнэж, ялангуяа практикт болон сургалтанд нэгдмэл нэг ойлголт төсөөлөл бүрдүүлэх үүднээс социологийн судлах зүйлийг дараах байдлаар тодорхойлж бас болно. Үүнд:

Социологийн судлах зүйл нь:

А/ Нийгмийн социаль системүүдийн /нийгэм, нийтлэг, бие хүн/ үүсэх оршин тогтнох, өөрчлөгдөн хөгжих ерөнхий ба өвөрмөц социаль хууль,

Б/ Социаль систем ба бусад системийн хоорондын харилцан үйлчлэл, нөлөөллийн илэрхийлэл болох нийгэм-биологийн, нийгэм-сэтгэл зүй, нийгэм-улс төрийн, нийгэм-эдийн засгийн г.м хуулиуд,

В/ Эдгээр хуулиуд нийгмийн тодорхой хүрээ, бие даасан дэд хэсэг салаа салбар, тодорхой үзэгдэл, юмсад илрэх хэлбэр, үйлчлэх механизм мөн гэж тодорхойлж болно.

Социологийн судлах зүйлийг ингэж тодорхойлох нь дараах ач холбогдолтой.

- Энэ өгүүлэлд авч үзсэн түгээмэл тохиолдох гурван өөр хандлагыг ерөнхий утгаараа агуулна.
- Бас өрөөсгөл талыг нь даван туулж чадна. Ингэснээрээ системтэй ойлгоц бүрэлдэхэд ач холбогдолтой.
- Социологи нь философийн нэг хэсэг биш, нийгмийн бие даасан тодорхой шинжлэх ухаан гэдэг нь зүй ёсоор урган гарна.
- Тодорхой утгаар ерөнхий байгаа нь манайд социологи олон ургальч үндсэн дээр хөгжиж, нэг биш харин олон урсгал, чиглэл үүсэх нөхцлийг бүрдүүлнэ.
- Социологи нь нийгмийн тухай социологийн ерөнхий онол, тусгай ба салбар социологи, эмпирик судалгааг багтаасан харилцан холбоо уялдаа бүхий салбарласан бүтэцтэй шинжлэх ухаан болохыг нөхцөлдүүлнэ.
- Социологи нь зөвхөн судалгааны арга гэсэн ойлголт төсөөллийг өөрчлөхөд нөлөөгөө үзүүлж социологи болон нийгмийн бусад шинжлэх ухааны хоорондын холбоо хамаарлыг зөв ойлгож тогтооход түлхэц болно.